

АКАДЕМИЧ П.НЯМДАВААГИЙН НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



Вирвс судлалын тулгамдсан асуудлаар 2 жил тутамд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж эхэлснээс хойш 16 дахь удаагийн хурал 2017 оны есдүгээр сарын 7-ны одор Кемпинский зочид буудалд болж байна. Вирвс судлалын тулгамдсан асуудлын чиглэлээр манай улсад болон дэлхий дахинд тулгамдаж байгаа асуудлаар эрдэмтэн, судлаачид дэлгэрэнгүй мэдээлэл солилцож, мэдлэг туршлагаа хуваалцдаг уламжлалтай.

ЭМЯ, Монголын Анагаах Ухааны Академи, ХОСҮТ, ЗОСҮТ болон мэргэжлийн бусад холбоодуудтай хамтран зохион байгуулж байгаа энэ удаагийн Вирвс судлалын тулгамдсан асуудлууд эрдэм шинжилгээний Үндэсний бага хурлыг Монгол Улсын хvний гавьяат эмч, Шинжлэх Ухааны Академийн жинхэнэ гишvүн, Анагаах Ухааны доктор, профессор П.Нямдаваагийн 70 насны ойд зориулж байгаагаар онцлог юм.

Академич П.Нямдаваа бол Монгол Улсад вирвс судлалын албын vндсийг тавьж, сургалтын тогтолцоог бvрдvүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Тvвний нор их ходолморийн vр дvнд мэргэжлийн олон судлаачтай, эрдэмтэдтэй болж, вирвсийн шинэ шинэ халдварт овчнийг Монгол Улсад гарах, тархахаас амжилттай сэргийлж чадах туршлагатай болоод байна.

Академич П.Нямдаваа бол Монголд тодийгvй дэлхийд данстай нэрт вирвс судлаач бoгoод энэ чиглэлээр дэлхий дахинд Монгол Улсыг толоолох бахархан дуурайх эрдэмтэн юм.

Академич П.Нямдаваа бол зовхон эрдэмтэн, багш тодийгvй Монгол Улсын тор,

нийгмийн нэрт зүтгэлтэн юм. Тэрээр Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар хэд хэдэн сонгогдож, томилогдон ажиллаж байхдаа эрүүл мэндийн салбарын бодлого чиглэлийг тодорхойх эрхзүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Академич П.Нямдаваа нь Шинжлэх Ухааны Академийн Анагаах ухааны Бага чуулганы даргаар ажиллаж байгаад Бага чуулганы гишүүдийн хамт Монголын Анагаах Ухааны Академиыг үүсгэн байгуулж, Ерөнхийлогчоор нь 8 жил ажиллаж байжээ. Энэ хугацаанд, монголын анагаах ухааны сор болсон эрдэмтэн мэргэдийг эгнээндээ нэгтгэж, Монголын Анагаах Ухааны Академийн үйл ажиллагааг толовшуулж, тогтворжуулах, гадаад, дотоод харилцааг оргожүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Академич П.Нямдаваа бол Монголын үе үеийн эрдэм оюун тоголдор олон зуун мэргэдийг эрдэм ухааны зүгт оройлон тэргүүлсэн номын их багштан билээ хэмээн Вирүс судлалын тулгамдсан асуудлууд эрдэм шинжилгээний Үндэсний бага хуралд оролцогчид онцлон тэмдэглэж гүн хүндэтгэлээ илэрхийллээ.